

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/40/НА/-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 89898557 цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
 84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
 Утас: 976-70433061, Факс: 976-70433061
 E-mail: khovd@audit.gov.mn

АЙМГИЙН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН
 ДАРГА Б.САНДАГСҮРЭН ТАНАА

2022.02.10 № 2/15
 танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР



Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Албан шаардлага	13
4.3 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,897,159.01	17,660,438.01
33	АВЛАГА	1,284,831.00	175,806.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,047,500.00	00.00
335	Бусад авлага	237,331.00	175,806.00
3351	Байгууллагаас авах авлага	237,331.00	175,806.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,612,328.01	17,484,632.01
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	330,000.00
354	Хангамжийн материал	16,612,328.01	17,154,632.01
35410	Бичиг хэргийн материал	143,196.00	235,000.00
35420	Аж ахуйн материал	1,071,334.00	1,071,334.00
35440	Түлш, шатах тослох материал	00.01	00.01
35470	Бусад хангамжийн материал	15,397,798.00	15,848,298.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	113,694,363.84	97,121,376.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	113,694,363.84	97,121,376.53
392	Биет хөрөнгө	113,694,363.84	97,121,376.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,746,100.00	124,746,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	124,746,100.00	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,314,737.00	91,580,127.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67,572,094.82	-57,115,972.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,439,299.00	66,458,059.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,567,577.34	-41,880,837.02
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	38,055,000.00	38,055,000.00
39217	Ном	25,000.00	25,000.00
39301	Програм хангамж	3,250,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,250,000.00	-1,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	131,591,522.85	114,781,814.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,200.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,200.00
413	Өглөг	00.00	2,200.00
4136	Бусад өглөг	00.00	2,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	131,591,522.85	114,779,614.54
51	Засгийн газрын хувь оролцоо	131,591,522.85	114,779,614.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	169,177,150.00	169,177,150.00
51101	Өмч: - төрийн	169,177,150.00	169,177,150.00
512	Хуримтлагдсан үр дүн	-41,863,697.15	-54,397,535.46
51210	Өмнөх үеийн үр дүн	-41,863,697.15	-37,585,627.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-16,811,908.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,278,070.00	00.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	131,591,522.85	114,781,814.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	981,822,000.00	600,710,200.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,875,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,875,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,875,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,875,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	942,947,000.00	600,710,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	435,600,000.00	124,325,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	400,000,000.00	13,125,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,370,000.00	22,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	88,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,230,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	507,347,000.00	476,384,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	507,347,000.00	476,384,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	960,843,804.63	617,522,108.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,843,804.63	617,522,108.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	927,893,055.99	591,604,942.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,645,748.00	181,436,279.00
210101	Үндсэн цалин	171,571,748.00	136,864,594.00
210102	Нэмэгдэл	00.00	38,415,685.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,074,000.00	6,156,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,639,164.36	23,560,688.00
210201	Тэтгэврийн даатгал	15,510,117.36	16,306,952.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,818,458.00	1,813,434.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,431,236.00	1,450,748.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352,670.00	362,687.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,526,683.00	3,626,867.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,312,976.01	26,057,243.00
210401	Бичиг хэрэг	2,273,246.00	1,740,431.00
210402	Тээвэр, шатахуун	23,965,662.01	17,661,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,516,068.00	6,039,112.00
210404	Ном, хэвлэл	1,558,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	416,700.00
2105	Нормативт зардал	370,000.00	308,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	370,000.00	308,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,802,900.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,802,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,950,700.00	6,122,200.00
210702	Дотоод албан томилолт	2,950,700.00	6,122,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,778,907.00	181,169,391.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	197,600,907.00	179,360,291.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,000.00	214,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	421,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	487,995,560.62	171,147,941.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	416,440,479.00	94,422,304.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,312,395.00	57,002,649.99
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,242,686.62	19,722,987.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,950,748.64	25,917,166.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,064,382.00	25,684,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,986,100.00	23,864,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,078,282.00	1,820,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,886,366.64	232,366.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,978,195.37	-16,811,908.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,978,195.37	-16,811,908.31

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	-67,320,078.52	106,135,141.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	-67,320,078.52	106,135,141.48
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,456,381.37	25,456,381.37
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	-41,863,697.15	131,591,522.85
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	-41,863,697.15	131,591,522.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,278,070.00	4,278,070.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	-37,585,627.15	135,869,592.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	4,278,070.00	00.00	-4,278,070.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,811,908.31	-16,811,908.31
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,177,150.00	00.00	-54,397,535.46	114,779,614.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	942,947,000.00	601,757,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	942,947,000.00	601,757,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	435,600,000.00	125,373,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	400,000,000.00	13,125,600.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,370,000.00	22,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	88,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,230,000.00	1,047,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	507,347,000.00	476,384,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	507,347,000.00	476,384,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	942,947,000.00	601,757,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,947,000.00	601,757,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,027,033.36	575,993,834.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,412,199.36	173,525,753.00
210101	Үндсэн цалин	130,792,399.36	122,890,917.35
210102	Нэмэгдэл	34,481,400.00	44,520,836.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,138,400.00	6,113,999.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,870,600.00	23,762,700.00
210201	Тэтгэврийн даатгал	16,094,200.00	16,721,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,694,100.00	1,760,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,355,300.00	1,408,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338,800.00	352,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,388,200.00	3,520,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,311,421.00	26,633,712.00
210401	Бичиг хэрэг	2,330,000.00	1,940,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,965,273.00	17,661,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,516,148.00	6,415,112.00
210404	Ном, хэвлэл	1,500,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	416,700.00
2105	Нормативт зардал	370,000.00	308,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	370,000.00	308,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,800,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,950,700.00	6,181,822.00
210702	Дотоод албан томилолт	2,950,700.00	6,181,822.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,227,938.00	184,449,647.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,049,938.00	182,261,647.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,000.00	214,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	468,684,175.00	159,331,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	411,831,675.00	95,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,852,500.00	64,331,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,919,966.64	25,763,866.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,986,100.00	25,531,500.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,986,100.00	23,864,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	1,666,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,933,866.64	232,366.00
213401	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,933,866.64	232,366.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,384,600.00	476,152,234.00	-232,366.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,384,600.00	476,152,234.00	-232,366.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,853,100.00	450,620,734.00	-232,366.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,020,300.00	173,525,753.00	-2,494,547.00
210101	Үндсэн цалин	138,660,900.00	122,890,917.35	15,769,982.65
210102	Нэмэгдэл	34,481,400.00	44,520,836.00	10,039,436.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,878,000.00	6,113,999.65	3,235,999.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,762,700.00	23,762,700.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	16,721,900.00	16,721,900.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,760,200.00	1,760,200.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,408,200.00	00.00	-1,408,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352,000.00	352,000.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,520,400.00	4,928,600.00	1,408,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,731,900.00	26,633,712.00	-98,188.00
210401	Бичиг хэрэг	1,940,900.00	1,940,900.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	17,661,000.00	17,661,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,513,300.00	6,415,112.00	-98,188.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,700.00	416,700.00	0.00
2105	Нормативт зардал	308,300.00	308,300.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	308,300.00	308,300.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	1,800,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	1,800,000.00	0.00

2107	Томилолт, зочны зардал	6,465,000.00	6,181,822.00	-283,178.00
210702	Дотоод албан томилолт	6,465,000.00	6,181,822.00	-283,178.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,189,000.00	184,449,647.00	2,260,647.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,000,000.00	182,261,647.00	2,261,647.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	220,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,000.00	214,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	54,000.00	-1,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33575900.00	33958800.00	382,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,575,900.00	18,958,800.00	382,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25531500.00	25531500.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,531,500.00	25,531,500.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,864,800.00	23,864,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,864,800.00	00.00	23,864,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	1,666,700.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	476,384,600.00	476,152,234.00	-232,366.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	476,384,600.00	476,152,234.00	-232,366.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	476,384,600.00	476,152,234.00	-232,366.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	14.00	1.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	03.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,373,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,373,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,373,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,373,100.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,373,100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,373,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,373,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	93,625,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,047,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зориулалт бус зарцуулалт, Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, НББ тайлагналтай холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 01 дүгээр сарын 30-нээс 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтвортой байдлыг төлөвшүүлж, хүний хөгжлийг хангасан “Стандарттай Ховд” хөтөлбөрийг дэмжиж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэн, ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилтын дор стратегийн дараах 9 зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлыг үнэлж дүгнэх, мэргэжил аргагүйгээр хангах журмыг шинэчлэн мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллах

- Хүний хөгжлийг хангасан, “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийн олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангах хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх

- Аймгийн эдийн засгийн өсөлтийг хангаж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүний хөгжлийг дэмжих замаар амьдралын чанарыг сайжруулах
- Орон нутгийн өмчийн харилцааг боловсронгуй болгож үр ашгийг дээшлүүлэх
 - НӨУБ-ын сонгуультаан, ажилтнуудын манлайллыг хангаж, хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх
 - Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон үзэл баримтлалыг сурталчлан таниулах
 - Иргэд олон нийтийг идэвхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж Төр-Иргэний хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үүрэг, итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлэх
 - НӨУБ-ийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн ил тод байдлыг хангах
 - Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг үе шатгүйгээр нэвтрүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт оржээ. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Тухайн онд байгууллагын удирдлагаас болон харьяалах дээд шатны төсвийн захирагчаас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, түүнчлэн тухайн байгууллагад мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, түүнчлэн эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 476,384.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,763.8 мянган төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 3811.0 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,809.7 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Өмнөх оны үзүүлэлтэй харьцуулахад дансны авлагын үлдэгдэл 1,109.0 мянган төгрөгөөр буурсан, бараа материалын үлдэгдэл 872.3 мянган төгрөгөөр өссөн, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг 16,579.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны эхний үлдэгдэл дэх 1,284.8 мянган төгрөгийн 237.3 мянган төгрөг нь бусад зардлын тооцооны авлага, 1,047.5 мянган төгрөг нь татаас санхүүжилтийн авлага байсан ба тайлант оны эцэст 175.8 мянган төгрөгийн бусад зардлын тооцооны авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 16,612.3 мянган төгрөг байсан бол оны эцэст 17,484.6 мянган төгрөг болж 872.3 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 50,622.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 49,750.6 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 350,830.1 мянган төгрөг байсан бол оны эцэст 318,764.3 мянган төгрөг болж 32,065.9 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.01.29-ны 07 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан 40 нэр төрлийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Тайлант оны эхэнд өр төлбөрийн дансны үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 2.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 131,591.5 мянган төгрөг байсан ба оны эцэст 114,779.6 мянган төгрөг болж тайлант онд 16,811.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд 4,278.1 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийн бууруулах бичилт хийгдсэн ба нийт хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл (54,397.5) мянган төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсвийн төсөлд 2021 оны нийт зардлыг 468,884.6 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 468,884.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба дээд шатны төсвийн захирагч тус байгууллагад 476,384.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 476,384.6 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 476,152.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулагдаагүй 232.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 476,152.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 2,494.5 мянга, хангамж, бараа материалын зардлыг 98.2 мянга, томилолт, зочны зардлыг 283.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2,260.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 382.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас цагаатгалын ажил удирдан зохион байгуулах улсын комиссын шийдвэрээр 80,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилт 8,700.0 мянга, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бусад эх үүсвэрээс 22,500.0 мянга, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 13,125.6 мянга, нэмэлт санхүүжилтийн данснаас урьд онд татан төвлөрүүлсэн хоорондын тооцооны авлага 1,047.5 мянга, нийт 125373.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн дээрх эх үүсвэрийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь оруулж, 1 мэдээллийг огт байршуулаагүй, 3 мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

Үүнд: Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш 186,884.1 мянган төгрөгийн худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 16,540.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 12,333.0 мянган төгрөгийн зарлагыг тус тус мэдээлээгүй зөрчлийг аудитын явцад залруулав.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохыг таслан зогсоох” 1 зөвлөмж өгөгдсөн боловч 2021 онд тухайн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохыг таслан зогсоох албан шаардлагын хэрэгжилт, бараа материал, шатахууны зарцуулалтад анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 126550.2 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс 102894.7 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчлийг залруулж, 18,259.7 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 5395.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 160.0 мянган төгрөгийн гэрийн өрх, 275.0 мянган төгрөгийн аяллын ширээ сандал, 2,200.0 мянган төгрөгийн камер, 950.0 мянган төгрөгийн шагайн харвааны ком хэрэгсэл зэргийг бараа материал болон үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхгүйгээр шууд зарлагаар бүртгэснийг залруулан үлдэгдлээр тусгаж тайлагнасан.
2. Шилэн дансны цахим мэдээллийн санд дутуу мэдээлсэн мэдээллийг аудитын явцад нөхөж оруулсан.
3. Хөтөлбөр арга хэмжээ, үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тайлан, илтгэх хуудас бүрэн бус, анхан шатны баримтын иж бүрэн, хүчин төгөлдөр байдал хангагдаагүй, дутуу нийт 99,309.7 мянган төгрөгийн баримтын бүрдлийг хангуулж, зөрчил арилгуулсан

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд нийт 102894.7 мянган төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг залруулан 2022 оны 02 дугаар сарын 09-ны тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

4.2 Албан шаардлага

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохыг таслан зогсоох” 1 зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 58.2. “Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ”, 6.4.2. “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 25 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, гэсэн заалттай тус тус нийцээгүй, мөн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг зориулалт бус зардлын эдийн засгийн ангиллаас сар бүр хувь иргэнд 169.7 мянган төгрөгийг нэмэгдэл тэтгэвэр утгаар олгож байгаа нь холбогдох хууль, журамд нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2017 оны

197 дугаар тогтоолоор баталсан Ахмадын сан байгуулах журмын 2.1 Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ... 2.1.1. “аж ахуйн нэгж, байгууллага, төсөвт байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвөөс цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө” гэсэн заалттай нийцүүлж ахмадын сан бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

2. Засгийн газрын тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож ажиллах Засгийн газрын 43 дугаар тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангахгүйгээр сургалт арга хэмжээнд 7,721.0 мянга, хүндэтгэлийн арга хэмжээнд 11,782.0 мянга, төлөөлөгчдийн өдөр, иргэдийн төлөөлөгчдийн болон тэргүүлэгчдийн хуралдаанд 11751.2 мянга, ном худалдан авахад 2,340.0 мянга нийт 33,594.2 мянган төгрөгийн зардал үрэлгэн зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл “төсвийн зарчим” ... 6.4.1 -д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцүүлж төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх.

3. НББ тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тухайн байгууллагад мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцүүлж НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ИТХ	7	126550.2	3	102894.7			1	18259.7	3	5395.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.ДОЛЖИНЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	Аймгийн ИТХ	7	126550.2	3	102894.7	1	18259.7	3	5395.8
---	-------------	---	----------	---	----------	---	---------	---	--------

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР
 АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН
 ТАЙЛАНГ БИЧСЭН:
 АУДИТОР: Б.ДОЛЖИНЖАВ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 35 А/2190428

Ховд

ХОА-2022-40/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд тус байгууллага өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намуудад 18259.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 58.2. "Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ", 6.4.2. "төрийн чиг үүрэгт хамарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 25 дугаар зүйлийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгодог байдлыг таслан зогсоож 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газар¹ т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарийн бичгийн дарга Б.Сандагсүрэн, нягтлан бодогч Б.Даваадорж-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

А.ЦЭЦЭГСҮРЭН
Б.ДОЛЖИНЖАВ

¹ Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагараа баг, ЗДТГ-ын 3 баахар, Утас: 70433061, 70432545

